



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/25

Маңдалговь

“Монгол эр хүн” сэдэвт сургалт  
зохион байгуулах тухай

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5, 18.1.6, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/23,27 тоот “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн тогтвортой байдлыг хангах, Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, эрэгтэйчүүдийн нийгэмдээ үзүүлэх нөлөө, үнэ цэнийн талаар олон нийтэд мэдээллийг өгч соён гэгээрүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эрчүүдээ хайрлая” үйл ажиллагааг 2023 оны 3 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгуулсугай.

2. “Монгол эр хүн” сэдэвт сургалтыг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, хөтөлбөрийг 2 дугаар, шаардагдах зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 883,300 (Найман зуун наян гурван мянга гурван зуу) төгрөгийн зардлыг Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1.3 дахь заалтыг үндэслэн Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уранбайгаль), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Уранбайгаль), гишүүдэд даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

482301049

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2023 оны 3 дугаар сарын 15 ны өдрийн  
14/25 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт



**“ЭРЧҮҮДЭЭ ХАЙРЛАЯ” АЯНЫ ХҮРЭЭНД “МОНГОЛ ЭР ХҮН”  
СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Уранбайгаль

(Гэр бүлийн хөгжил хариуцсан ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

Г.Баярсайхан

(Хүүхдийн хөгжил, хамгааллын асуудал хариуцсан  
ахлах мэргэжилтэн)

Ш.Эрдэнэсүвд

(Хүүхдийн эрхийн улсын байцаагч)

Б.Түвшинбаяр


(Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн)

Б.Биндэръяа

(Архив, бичиг хэрэг хариуцсан ажилтан)

---oOo---

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн  
1125 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



**АМЬДРАЛЫН ЗӨВ ДАДАЛ ХЭВШЛИЙГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД  
ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ ЖИЛИЙН НЭЭЛТ,  
“ЭРЧҮҮДЭЭ ХАЙРЛАЯ” УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГИЙН  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

**ЗОРИЛГО:**

Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл байдал, эрэгтэйчүүдийн нийгэмдээ үзүүлэх нөлөө, үнэ цэнийн талаар олон нийтэд мэдээллийг өгч соён гэгээрүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ БАЙГУУЛЛАГА:**

- ❖ Аймгийн Засаг даргын Тамгын газар
- ❖ Эрүүл мэндийн газар, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд
- ❖ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

**ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА:**

- ❖ Төв халхын дуулалт жүжгийн театр
- ❖ Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүд

**ХААНА:**

- ❖ Төв халхын дуулалт жүжгийн театрт

**ХУГАЦАА:**

- ❖ 2023 оны 3 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд  
**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР:**

**2023 оны 3 дугаар сарын 20-ны өдөр:**

- 13:00-14:00 цагт: Эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл
  - Үзүүлэн танилцуулга
  - Гарын авлага
- 14:00-14:20 цагт: Нээлтийн үг хэлэх:  
(Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат, ЭМГ-ын дарга Б.Алтантөгс)
- 14.20-15:00 цагт: “Эрчүүдийн эрүүл мэндийн өнөөгийн байдал” сэдэвт илтгэл  
(Илтгэгч: ЭМГ-ын УТСХ-ийн дарга, эрэгтэйчүүдийн эмч Ц.Энхсайхан)
- 15.00-17.00 цагт: “Монгол эр хүн” сэдэвт илтгэл  
(Илтгэгч: Гэр бүл судлаач Ж.Баясгалан )
- 17:00-17:30 цагт: Ахмад эмчийн сургамж үг  
(МУ-ын Эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан Ш.Балжинням)
- 17:30-18:00 цагт: “Эрэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудал” сэдэвт  
нээлттэй хэлэлцүүлэг

- **Хаалтын үйл ажиллагаа**
  - Урлагийн тоглолт
  - Аймгийн Засаг дарга Ц.Мөнхбат үг хэлэх.
  - Зураг авалт

**2023 оны 3 дугаар сарын 21-ний өдөр**

- **09:00-13:00, 14:00-18:00 цагт: Эрэгтэйчүүдийн болон нарийн мэргэжлийн эмч нарын үнэ төлбөргүй урьдчилан сэргийлэх үзлэг: (Сайнцагаан сумын ЭМТ-д)**
  - Цусан дахь сахар тодорхойлох
  - Цусан дахь холестерин тодорхойлох
  - Зүрхний цахилгаан бичлэг
  - Хэвлийн ЭХО
  - Цээжний рентген оношлогоо
  - Эрэгтэйчүүдийн эмчийн үзлэг, зөвлөгөө
  - Дотрын эмчийн үзлэг, зөвлөгөө

---oOo---

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,  
залуучуудын хөгжлийн газрын даргын  
2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн  
А/25 дугаар тушаалын 03 дугаар хавсралт



**“ЭРЧҮҮДЭЭ ХАЙРЛАЯ” АЯНЫ ХҮРЭЭНД “МОНГОЛ ЭР ХҮН”  
СЭДЭВТ СУРГАЛТАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ**

| №                               | Зардлын ангилал      | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Оролцогчдын тоо | Тоо ширхэг | Нийт үнэ |
|---------------------------------|----------------------|-------------|----------------|-----------------|------------|----------|
| <b>Багшийн хөлс</b>             |                      |             |                |                 |            |          |
| 1                               | Илтгэгч багшийн хөлс | цаг         | 2,000          | 200             | 2          | 800,000  |
| <b>Дүн</b>                      |                      |             |                |                 |            | 800,000  |
| <b>Сургалтын хэрэглэгдэхүүн</b> |                      |             |                |                 |            |          |
| 1                               | Бичгийн цаас         | ш           | 18,300         | -               | 1          | 18,300   |
| 2                               | Принтерийн хор       | ш           | 65,000         | -               | 1          | 65,000   |
| <b>Дүн</b>                      |                      |             |                |                 |            | 83,300   |
| <b>Нийт дүн</b>                 |                      |             |                |                 |            | 883,300  |

-----oOo-----